



**“ХОТ ДЕВЕЛОПМЕНТ” ХК – ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 02 сарын 28-ны өдөр

Дугаар 1

Улаанбаатар

**Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн
талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг
батлах тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, Тооллогын комиссын дүнг үндэслэн “Хот Девелопмент” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ** нь:

1. “Хот Девелопмент” ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хангалттай гэж үзсүгэй.
2. “Хот Девелопмент” ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА  Ч.СОЛОНГО





**“ХОТ ДЕВЕЛОПМЕНТ” ХК – ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 02 сарын 28-ны өдөр

Дугаар 2

Улаанбаатар

**Г Санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтэй
танилцсан тухай Г**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15 дахь заалт, Тооллогын комиссын дүнг үндэслэн “Хот Девелопмент” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ** нь:

1. “Хот Девелопмент” ХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлттэй танилцсанд тооцсугай.

ХУРЛЫН ДАРГА



Ч.СОЛОНГО



**“ХОТ ДЕВЕЛОПМЕНТ” ХК – ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 02 сарын 28-ны өдөр

Дугаар 3

Улаанбаатар

Г “Хот Девелопмент” ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, Т төсвийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15 дахь заалт, Тооллогын комиссын дүнг үндэслэн “Хот Девелопмент” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ** нь:

1. “Хот Девелопмент” ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг Хавсралт №1-ээр баталсугай.
2. “Хот Девелопмент” ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны төсвийг Хавсралт №2-оор баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Ч.СОЛОНГО

"Хот Девелопмент" ХК-ийн 2023 оны 2 сарын 28-ны өдрийн
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 3 тоот
тогтоолын Хавсралт №1



Компанийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөө

Хот Девелопмент ХК нь 2023 онд мэдээлэл технологийн үйл ажиллагаа болон төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх гэсэн үйл ажиллагааны шинэ 2 чиглэлээр бизнесийн үйл ажиллагаагаа явуулж одоогийн санхүүгийн үзүүлэлтээ сайжруулах, дотоод зохион байгуулалтдаа өөрчлөлт хийх, чадварлаг хүний нөөцөөр багаа бүрдүүлэхэд анхааран ажиллахаас гадна стратеги, зорилго зорилтоо тодорхойлон ажиллахаар төлөвлөөд байна.

Хот Девелопмент ХК-ийн 2023 онд хэрэгжүүлэх зорилтууд:

1. Компанийн дүрмийн өөрчлөлтөөр мэдээлэл технологи, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх гэсэн үйл ажиллагааны чиглэлийг одоогийн үйл ажиллагааны чиглэлд нэмж оруулах, шаардлагагүй үйл ажиллагааны чиглэлийг хасах, өөрчлөх;
2. Компанийн дүрмийн өөрчлөлтөөр нийт гаргасан хувьцааны тоог нэмэгдүүлэх буюу хаалттай хүрээнд нэмж хувьцаа гаргах;
3. Холбогдох хууль, журмын хүрээнд нийт хувьцаа эзэмшигчдэдээ нэмж хувьцаа гаргахтай холбоотой шаардах эрхээ хэрэгжүүлэх боломжоор бүрэн хангах;
4. Хаалттай хүрээнд нэмж хувьцаа гаргах замаар стратегийн хөрөнгө оруулагчаас хөрөнгө татан төвлөрүүлж хувь нийлүүлсэн хөрөнгөө нэмэгдүүлэх;
5. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тусгай зөвшөөрлийн хүсэлт гаргах;
6. Хүний нөөцийн бүтэц бүрэлдэхүүнийг тодорхойлох, чадварлаг боловсон хүчнээр багаа бүрдүүлэх;
7. Шинэ төсөл, хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх;
8. Хувьцаа эзэмшигчдэд компанийн үйл ажиллагаа болон санхүүгийн мэдээ мэдээллийг нээлттэй, ил тод, түргэн шуурхай хүргэх дотоод тогтолцоог бий болгох.

"Хот Девелопмент" ХК-ийн 2023 оны 2 сарын 28-ны өдрийн
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 3 тоот
тогтоолын Хавсралт №2



Компанийн 2023 оны үйл ажиллагааны төсөв

1. "Хот Девелопмент" ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд үндэслэн хаалттай хүрээнд нэмж хувьцаа гаргах замаар 2,050,000,000 (хоёр тэрбум тавин сая) төгрөгийн санхүүжилтийг татан төвлөрүүлж, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхэд зарцуулахаар төсвийг батлахаар тогтов.



**“ХОТ ДЕВЕЛОПМЕНТ” ХК – ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 02 сарын 28-ны өдөр

Дугаар 4

Улаанбаатар

**Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг
томилох тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, Тооллогын комиссын дүнг үндэслэн “Хот Девелопмент” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ** нь:

1. “Хот Девелопмент” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүдээр:
 1. Э.Баярбат
 2. Ч.Солонго
 3. Б.Чулуунсүх
 4. М.Дөлгөөн
 5. Л.Алтангэрэл
 6. С.Отгонсайхан

2. “Хот Девелопмент” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдээр:
 1. Э.Эрдэнэбаатар
 2. Э.Ганбаатар
 3. Б.Лхамдэгд нарыг тус тус Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдээр сонгогдсоныг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Ч.СОЛОНГО



**“ХОТ ДЕВЕЛОПМЕНТ” ХК – ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 02 сарын 28-ны өдөр

Дугаар 5

Улаанбаатар

**Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдийн цалин,
үйл ажиллагааны зардлын төсөв батлах тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, Тооллогын комиссын дүнг үндэслэн “Хот Девелопмент” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ** нь:

1. “Хот Девелопмент” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүний цалинг 100,000 /нэг зуун мянган/ төгрөг байхаар тогтоосугай.
2. “Хот Девелопмент” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны зардлын төсвийг 600,000 /зургаан зуун мянган/ төгрөгөөр тогтоосугай.

ХУРЛЫН ДАРГА



Ч.СОЛОНГО



**“ХОТ ДЕВЕЛОПМЕНТ” ХК – ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 02 сарын 28-ны өдөр

Дугаар 6

Улаанбаатар

**Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс гаргасан ногдол ашиг тараахгүй
тухай шийдвэрийг батлах тухай**

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх заалт, 62 дугаар зүйлийн 62.1.15 дахь заалт, Тооллогын комиссын дүнг үндэслэн “Хот Девелопмент” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ** нь:

1. “Хот Девелопмент” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс гаргасан 2022 оны тайлант хугацаанд үйл ажиллагаа явуулаагүй, алдагдалтай ажилласан тул ногдол ашиг тараахгүй байх тухай шийдвэрийг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Ч.СОЛОНГО



**“ХОТ ДЕВЕЛОПМЕНТ” ХК – ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 02 сарын 28-ны өдөр

Дугаар 7

Улаанбаатар

**Хаалттай хүрээнд нэмж хувьцаа гаргах,
хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өсгөхийг батлах тухай**

Компанийн тухай хуулийн 4 дүгээр зүйл, 55 дугаар зүйл, 62 дугаар зүйлийн 62.1.3, 62.1.15 дахь заалт, 83.8 дахь хэсэг, 87 дугаар зүйл, 88 дугаар зүйл, 89 дүгээр зүйл, Тооллогын комиссын дүнг үндэслэн “Хот Девелопмент” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ** нь:

1. Нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 20,500,000 (хорин сая таван зуун мянга) ширхэг энгийн хувьцааг нэмж гаргасугай.
2. Хувьцаа нэмж гаргаж байгаатай холбогдуулан компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 2,050,000,000 (хоёр тэрбум тавин сая) төгрөгөөр нэмэгдүүлж, 2,897,005,400 (хоёр тэрбум найман зуун ерөн долоон сая таван мянга дөрвөн зуу) төгрөг байхаар тогтсугай.
3. Нэмж гаргаж буй хувьцааг компанийн хувьцаа эзэмшигч нар тэргүүн ээлжид худалдан авах эрхээ Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасан журмын дагуу хэрэгжүүлсний дараа үлдэх хэсгийг “Занн Корпорейшн Монголиа” ХХК-аас ирүүлсэн хаалттай хүрээнд хувьцаа худалдан авах захиалгын дагуу худалдахыг зөвшөөрсүгэй.
4. “Хот Девелопмент” ХК-аас дараах төрөл, үнэ, тоо, ширхэг бүхий энгийн хувьцааг хаалттай хүрээнд “Занн Корпорейшн Монголиа” ХХК-д эзэмшүүлсүгэй.

1	Хувьцааны төрөл	Энгийн хувьцаа
2	Эзэмшүүлэх хувьцааны тоо ширхэг	Хувьцаа эзэмшигч нар тэргүүн ээлжид хувьцаа худалдан авах эрхээ хэрэгжүүлсний дараа үлдэх хэмжээний хувьцаа
3	Хувьцааны нэгжийн үнэ	100 төгрөг
4	Хувьцааны нэрлэсэн үнэ	100 төгрөг
5. “Хот Девелопмент” ХК нь хаалттай хүрээнд нэмж хувьцаа гаргахтай холбогдуулан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг Гүйцэтгэх захиралд зөвшөөрсүгэй.



6. “Хот Девелопмент” ХК-ийн хувьцааг хувьцаа эзэмшигч нар болон “Занн Корпорейшн Монголиа” ХХК худалдан авахтай холбогдуулан талуудын хооронд байгуулах Хувьцаа худалдах, худалдан авах гэрээ, Эрх шилжүүлэх гэрээ байгуулах болон хувьцааг шилжүүлэхэд шаардлагатай гэж үзсэн бусад гэрээнүүд (тухайлбал, үнэт цаасны компаниуд, арилжааны банк зэрэг байгууллагууд болон эдгээрээс бусад үйлчилгээ үзүүлэгч нартай байгуулах гэрээнүүд)-д гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захиралд олгосугай.
7. “Хот Девелопмент” ХК хаалттай хүрээнд нэмж хувьцаа гаргаж буйтай холбогдуулан, компанийн дүрэмд оруулах нэмэлт, өөрчлөлтийг тусдаа тогтоолоор батлах бөгөөд нэмэлт өөрчлөлт орсон дүрэм нь төрийн эрх бүхий байгууллагын зөвшөөрөл гарч, Улсын бүртгэлд бүртгэгдсэнээр хүчин төгөлдөр болно.
8. “Хот Девелопмент” ХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгө нэмэгдэж буйтай холбоотойгоор Монголын хөрөнгийн бирж болон Санхүүгийн зохицуулах хороонд холбогдох журмын дагуу мэдэгдэж, зөвшөөрөл авах, үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах ажлыг зохион байгуулахыг Гүйцэтгэх захиралд даалгасугай.
9. “Хот Девелопмент” ХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгө нэмэгдэж, үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт орсныг Монголын хөрөнгийн бирж болон Санхүүгийн зохицуулах хороо зөвшөөрч, нэмэлт хувьцаа бүртгэгдсэний дараа компанийн дүрэмд орсон нэмэлт, өөрчлөлтийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт хандаж бүртгүүлэх, шаардлагатай бусад арга хэмжээ авч ажиллахыг Гүйцэтгэх захиралд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Ч.СОЛОНГО





**“ХОТ ДЕВЕЛОПМЕНТ” ХК – ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 02 сарын 28-ны өдөр

Дугаар 8

Улаанбаатар

**Үйл ажиллагааны чиглэлд нэмэлт, өөрчлөлт
оруулахыг батлах тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, Тооллогын комиссын дүнг үндэслэн “Хот Девелопмент” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ** нь:

1. “Хот Девелопмент” ХК-ийн үйл ажиллагааны чиглэлд дараах чиглэлийг нэмсүгэй.
 - 1.1. Мэдээлэл технологийн үйл ажиллагаа
 - 1.2. Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх
2. Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газраас хуулийн этгээдийн үйл ажиллагааны чиглэлийн нэршилд өөрчлөлт оруулан баталсантай холбогдуулан, тус компанийн дүрмийн 1.4.b) -д заасан “гадаад худалдаа” гэсэн чиглэлийг “төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа” гэж өөрчлөн найруулсугай.
3. Бизнесийн зөвлөгөө өгөх чиглэлийг хэвээр үлдээснийг дурдсугай.
4. “Хот Девелопмент” ХК-ийн үйл ажиллагааны чиглэлд орсон өөрчлөлтийг компанийн дүрэмд тусдаа тогтоолоор батлах бөгөөд нэмэлт өөрчлөлт орсон дүрэм нь төрийн эрх бүхий байгууллагын зөвшөөрөл гарж, Улсын бүртгэлд бүртгэгдсэнээр хүчин төгөлдөр болно.

ХУРЛЫН ДАРГА



Ч.СОЛОНГО



**“ХОТ ДЕВЕЛОПМЕНТ” ХК – ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 02 сарын 28-ны өдөр

Дугаар 9

Улаанбаатар

Г

**Хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг
эдлүүлэх тухай**

Г

Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйл, Тооллогын комиссын дүнг үндэслэн “Хот Девелопмент” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ** нь:

1. “Хот Девелопмент” ХК нь хаалттай хүрээнд нэмж хувьцаа гаргаж буйтай холбогдуулан хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхоор хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах эрхийг тус компанийн хувьцаа эзэмшигчдэд эдлүүлэхээр тогтсугай.

ХУРЛЫН ДАРГА



Ч.СОЛОНГО



**“ХОТ ДЕВЕЛОПМЕНТ” ХК – ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 02 сарын 28-ны өдөр

Дугаар 10

Улаанбаатар

Шаардах эрхийг хэрэгжүүлэх тухай

Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь заалт, 53 дугаар зүйл, 54 дүгээр зүйл болон Тооллогын комиссын дүнг үндэслэн “Хот Девелопмент” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ** нь:

1. “Хот Девелопмент” ХК нь хаалттай хүрээнд нэмж хувьцаа гаргаж, компанийн үйл ажиллагааны чиглэлд нэмэлт, өөрчлөлт оруулсныг үндэслэн “Хот Девелопмент” ХК-ийн дүрмэнд нэмэлт, өөрчлөлт оруулж буйтай холбогдуулан 2023 оны 2 сарын 28-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсон ч эсрэг саналтай байсан эсхүл хуралд оролцоогүй хувьцаа эзэмшигчид нь хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхээ Компанийн тухай хуулийн 54 дүгээр зүйлд заасан журмын дагуу хэрэгжүүлэхээр тогтов.

ХУРЛЫН ДАРГА



Ч.СОЛОНГО



**“ХОТ ДЕВЕЛОПМЕНТ” ХК – ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 02 сарын 28-ны өдөр

Дугаар 11

Улаанбаатар

Г

Дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг батлах тухай

Г

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 болон 62.1.15 дахь заалтууд болон Тооллогын комиссын дүнг үндэслэн “Хот Девелопмент” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ** нь:

1. “Хот Девелопмент” ХК нь хаалттай хүрээнд нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 20,050,000 (хорин сая тавин мянга) ширхэг энгийн хувьцаа нэмж гаргаж, компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 2,050,000,000 (хоёр тэрбум тавин сая) төгрөгөөр нэмэгдүүлж 2,897,005,400 (хоёр тэрбум найман зуун ерөн долоон сая таван мянга дөрвөн зуу) төгрөг байхаар тогтсоныг, компанийн үйл ажиллагааны чиглэлд (i) Мэдээлэл технологийн үйл ажиллагаа, (ii) Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх чиглэл нэмэгдсэнийг, компанийн үйл ажиллагааны чиглэлээс “Гадаад худалдаа” гэсэн чиглэлийг “Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа” гэж өөрчлөн найруулсныг, бизнесийн зөвлөгөө өгөх чиглэлийг хэвээр үлдээснийг тус тус үндэслэн “Хот Девелопмент” ХК-ийн дүрэмд холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулан Хавсралт № 1 ёсоор баталсугай.
2. Нэмэлт өөрчлөлт орсон дүрэм нь төрийн эрх бүхий байгууллагын зөвшөөрөл гарч, Улсын бүртгэлд бүртгэгдсэнээр хүчин төгөлдөр болно.

ХУРЛЫН ДАРГА



Ч.СОЛОНГО